



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/12/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дундговь аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a> Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Oyun-Erdenet@audit.gov.mn">Oyun-Erdenet@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Batsaikhant@audit.gov.mn">Batsaikhant@audit.gov.mn</a> Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Doljinsurend@audit.gov.mn">Doljinsurend@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	8
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	12
4.1 Ерөнхий зүйл .....	12
4.2 Материаллаг байдал.....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
4.5.1 Завсрын аудитын талаар .....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
5. Аудитын илрүүлэлт .....	13
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

№ 2025.03.05 № 91

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэн, бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 79.2 сая төгрөгөөр өссөн байна.

Орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлснээр 2 төсвийн байгууллагын нийт 5 албан хаагч 40.6 сая төгрөгийн дэмжлэг авсан байна.

Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 16 дугаар тогтоолын дагуу сумдын Эмийн эргэлтийн санг татан буулгах шийдвэр гарч, тус сумын Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 105.4 сая төгрөгийн хөрөнгө, 27.8 сая төгрөгийн өр төлбөрийг ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэгтгэн бүртгэсэн байна.

Уг үйл явцуудыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

#### Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй

4825020310

болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 7 зорилт, 98 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 67.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр хугацаа хоцруулж ирүүлсэн болно.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	678,011.2	1,112,587.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	154,182.6	436,157.0
33	АВЛАГА	231,739.4	311,143.5
35	БАРАА МАТЕРИАЛ	176,314.1	249,511.5
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	115,775.0	115,775.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,069,706.1	3,080,405.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,069,706.1	3,080,405.4
39200	Биет хөрөнгө	3,049,352.2	3,060,129.2
39300	Биет бус хөрөнгө	20,353.9	20,276.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,747,717.3	4,192,992.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	21,964.6	113,501.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,964.6	113,501.5
41300	Өглөг	21,964.6	113,501.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,725,752.6	4,079,490.9
51	Засгийн газрын хувь оролцоо	3,725,752.6	4,079,490.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	430,159.4	430,159.4
51200	Хуримтлагдсан үр дүн	3,078,271.2	3,432,009.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	217,322.0	217,322.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,747,717.3	4,192,992.4

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,511,050.0	2,096,486.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	204,294.5	457,941.7
110	Орлогын албан татвар	160,138.2	366,897.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	160,138.2	366,897.3
113	Хөрөнгийн албан татвар	32,047.8	59,308.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	12,108.4	31,735.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	203,215.6	288,095.6
120	Нийтлэг татварын бус орлого	203,215.6	288,095.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,103,539.9	1,350,449.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,215,077.6	1,618,211.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,215,077.6	1,618,211.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,168,865.9	1,512,494.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,621.1	570,160.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,261.7	70,299.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,214.2	364,392.8
2104	Хангамж, бараа материалын зардал	48,274.8	61,675.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,608.8	28,760.0
2107	Томилолт, зочны зардал	18,111.8	20,126.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	248,945.7	8,895.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	361,827.7	388,185.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,211.7	105,716.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	295,972.4	478,275.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	4,025.2	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	104,495.2	60,809.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	195,502.4	417,465.6

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,528,704.2	3,528,704.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,546.0	1,546.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,530,250.2	3,530,250.2
9	Тайлант үеийн үр дүн	195,502.4	195,502.4
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,725,752.6	3,725,752.6
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,725,752.6	3,725,752.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-63,727.3	-63,727.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,662,025.3	3,662,025.3
19	Тайлант үеийн үр дүн	417,465.6	417,465.6
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,079,490.9	4,079,490.9

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,426,162.7	1,877,578.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	204,294.5	457,941.7
110	Орлогын албан татвар	160,138.2	366,897.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	160,138.2	366,897.3
113	Хөрөнгийн албан татвар	32,047.8	59,308.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	12,108.4	31,735.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,029.5	14,672.8
1181	Газрын төлбөр	4,078.9	8,649.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	8,413.6
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118,328.4	69,187.9
120	Нийтлэг татварын бус орлого	118,328.4	69,187.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,103,539.9	1,350,449.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	927,070.5	1,334,681.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	927,070.5	1,334,681.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	880,858.8	1,228,965.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,881.9	570,598.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,270.8	70,299.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,064.8	370,070.8
2104	Хангамж, бараа материалын зардал	48,286.1	64,579.2
2105	Нормативт зардал	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,576.8	32,160.0
2107	Томилолт, зочны зардал	18,005.4	17,374.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	248,945.7	8,895.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,827.2	94,988.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,211.7	105,716.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	499,092.2	542,897.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	438,093.5	210,922.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	438,093.5	210,922.9
2200	Дотоод эх үүсвэрээр	438,093.5	210,922.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-438,093.5	-210,922.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-25,000.0	-50,000.0

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	25,000.0	50,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	35,998.7	281,974.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	118,183.9	154,182.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	154,182.6	436,157.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,980,538.7	1,548,966.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,375,442.4	1,296,743.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,268,525.0	1,197,737.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	591,936.3	570,598.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,055.5	70,299.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	373,184.2	369,265.4
2104	Хангамж, бараа материалын зардал	59,015.5	54,247.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,351.1	37,966.5
2107	Томилолт, зочны зардал	19,850.0	16,183.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,609.7	3017.939.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,522.7	76,159.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,917.4	99,006.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,917.4	99,006.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	500,834.3	202,223.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	104,262.0	50,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,980,538.7	1,734,483.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	360,351.3	345,937.3
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,405,267.4	1,323,685.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	214,920.0	64,860.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	120,911.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	306,428.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,637.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,637.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,927.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	805.3
2104	Хангамж, бараа материалын зардал	10,331.7
2105	Норматив зардал	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,893.0
2107	Томилолт, зочны зардал	1,191.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,877.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,829.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,710.2
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,710.2
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,710.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	46,637.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,637.6
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,176.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,310.7

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг дарга нь эрхэм зорилгоо “Ардчиллыг бэхжүүлэн, нийгмийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлж, сумын нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн өргөн оролцоотойгоор шийдвэрлэн, тэдний нөөц боломжийг дайчлах замаар орон нутгийн тогтвортой, тэнцвэртэй хөгжлийг хангах” гэж тодорхойлжээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад өөрчлөлт ороогүй.

Харин төрийн албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл, урамшуулалтай холбоотой дараах тогтоолуудад өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- ✓ Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох”-ыг шинэчлэн тайлант оноос дагаж мөрдөхөөр,
- ✓ Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- ✓ Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-д нэмэлт өөрчлөлт орж, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дундговь аймгийн Сайхан-овоо сумын Засаг дарга нь дотоод аудитын нэгжгүй, дотоод аудитыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хийдэг бөгөөд тухайн онд тус сумын тусгай зориулалтын сан, төсөвт байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл хөтөлж, шалгагдагч байгууллагад танилцуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй боловч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны "Сумын эмийн эргэлтийн сан ОНӨААТҮГ-уудыг татан буулгах тухай" 16 дугаар тогтоолын дагуу сумдын Эмийн эргэлтийн санг /ЭЭС/ татан буулгаж, үлдэгдэл хөрөнгө болон өр төлбөрийг сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэгтгэсэн онцлог бүртгэл хийгдсэн байна.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 445,275.1 мянган төгрөгөөр буюу 11.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	154,182.6	436,157.0	281,974.4
Авлага	231,739.4	311,143.5	79,404.1
Бараа материал	176,314.1	249,511.5	73,197.4
Бусад эргэлтийн хөрөнгө	115,775.0	115,775.0	0.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,069,706.1	3,080,405.4	10,699.3
Үндсэн хөрөнгө	3,069,706.1	3,080,405.4	10,699.3
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>3,747,717.3</b>	<b>4,192,992.4</b>	<b>445,275.1</b>
Нийт өр төлбөр	21,964.6	113,501.5	91,536.9
Богино хугацаат өр төлбөр	21,964.6	113,501.5	91,536.9
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,725,752.6	4,079,490.9	353,738.3
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,747,717.3</b>	<b>4,192,992.4</b>	<b>445,275.1</b>

Дээрх хүснэгтээс харахад санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтэд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан данс нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн данснууд байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 281,974.4 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төлөвлөсөн зарим ажлууд хийгдээгүйгээс 256,816.3 мянган төгрөг зарцуулаагүй үлдсэн, мөн орон нутгийн татварын орлого нийт дүнгээр давж биелснээс ОНХО үлдэгдэл 126,215.4 мянган төгрөг болж тус тус өссөнтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 79,404.1 мянган төгрөгөөр өссөн нь ХХС-ийн үлдэгдэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамжин хийгдэж байгаа төсөл арга хэмжээний 97,619.2 мянган төгрөгийн авлага, ЗДТГ-ын дансанд ЭЭС-ийн 28,292.0 мянган төгрөгийн авлагыг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 73,197.4 мянган төгрөгөөр өссөн нь өвөлжилт сайхан байсантай холбоотой өвс тэжээлийн борлуулалт буурч, Мал хамгаалах сангийн өвс, тэжээлийн үлдэгдэл 62,848.0 мянган төгрөгөөр өссөн, мөн ЗДТГ-т ЭЭС-ийн 20,834.8 мянган төгрөгийн эмийн үлдэгдлийг шилжүүлэн бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 10,699.3 мянган төгрөгөөр өссөн нь ИТХ ажлын албатай болж төсвийн хөрөнгөөр 7,000.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, ЗДТГ-т ЭЭС-ийн 56,297.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэсэн, сумын ОНХО-аар бэлтгэсэн 126,400.0 мянган төгрөгийн хөрөнгө, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 31,650.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэж, холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл 91,536.9 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-т ЭЭС-ийн 33,364.1 мянган төгрөг, улсын төсвийн байгууллагын тогтмол зардлын өмнөх оны өглөг 63,727.3 мянган төгрөгийг тус тус тусган тайлагнасан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 353,738.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

**3.4.2 Орлого бүрдүүлэлт**

Сайхан-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Сумын 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 105 дугаар тогтоолоор тайлант онд 417,633.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 462,259.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 110.7 хувиар даван биелсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого  
/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
---------------	------------	-----------	-------	------

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1	2	3	4=3-2	5
Үйл ажиллагааны орлого /ИОТГХ/	71,500.0	98,977.0	27,477.0	138.4
Хадгаламжийн хүүгийн орлого	20,000.0	28,204.8	8,204.8	141.0
Хөрөнгө борлуулсны орлого		5,660.6	5,660.6	0.0
Бууны албан татвар	750.0	900.0	150.0	120.0
Улсын тэмдэгтийн хураамж	1,800.0	3,619.3	1,819.3	201.1
Хог хаягдлын үйлчилгээ	18,000.0	11,053.3	-6,946.7	61.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,500.0	0.0	-1,500.0	0.0
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	5,000.0	8,413.6	3,413.6	168.3
Газрын төлбөр	5,000.0	8,649.0	3,649.0	173.0
Малын тоо толгойн албан татвар	80,483.0	54,904.4	-25,578.6	68.2
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	3,500.0	3,504.4	4.4	100.1
Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татвар	206,800.0	234,054.8	27,254.8	113.2
<b>Татварын орлого</b>	<b>414,333.0</b>	<b>457,941.2</b>	<b>43,608.2</b>	<b>110.5</b>
Хүү торгууль	3,300.0	4,319.0	1,019.0	130.9
<b>Татварын бус орлого</b>	<b>3,300.0</b>	<b>4,319.0</b>	<b>1,019.0</b>	<b>130.9</b>
<b>Нийт орлогын дүн</b>	<b>417,633.0</b>	<b>462,260.2</b>	<b>44,627.2</b>	<b>110.7</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дараах нэр төрлийн орлого материаллаг дүнгээр тасарсан байна. Үүнд:

- Хог хаягдлын орлого 6,946.7 мянган төгрөгөөр тасарсан нь татварын байцаагч байхгүй, аймгийн Татварын газрын байцаагч хавсран гүйцэтгэдэг;
- Түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлого 1,500.0 мянган төгрөгөөр тасарсан нь хууль эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй;
- Малын тоо толгойн албан татвар 25,578.6 мянган төгрөгөөр тасарсан нь орон нутагт татварын байцаагч байхгүй, түүнчлэн малчид цахим систем ашиглан татвар төлөх мэдлэг дутуугаас шалтгаалсан байна.

Өмнөх аудитаар орон нутгийн татварын 13 нэр төрлийн орлогоос 7 нэр төрлийн орлогыг 52,365.3 мянган төгрөгөөр тасалсан зөрчилд зөвлөмж өгсөн байна. Тайлант онд татварын орлого нийт дүнгээр 44,627.2 мянган төгрөгөөр даван биелж, 3 нэр төрлийн орлого тодорхой шалтгааны улмаас тасарчээ. Энэ нь өмнөх онд тасарсан 7 нэр төрлийн орлогоос 4 нэр төрлийн орлогоор буурсан үзүүлэлттэй байна. Орон нутгийн татварын 3 нэр төрлийн орлогыг 34,025.3 мянган төгрөгөөр тасалсан зөрчил хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр боллоо.

Дараах нэр төрлийн орлого материаллаг дүнгээр давж биелсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагааны орлого 27,477.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд Эрдэнэс таван толгойн хувьцааны ногдол ашиг хуваарилсантай;
- Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварын орлого 27,254.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, нийт төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгодог болсон;
- Хадгаламжийн хүүгийн орлого 8,204.8 мянган төгрөгөөр давж биелсэн нь банк болон банк бус санхүүгийн байгууллага дахь иргэдийн хадгаламжийн орлого нэмэгдсэн;
- Улсын тэмдэгтийн хураамж 1,819.3 мянган төгрөгөөр давж биелсэн нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдээс 8 нэрийн барааны тусгай зөвшөөрөл сунгасантай холбоотой зөвшөөрлийн хураамж төлөгдсөн;
- Газрын төлбөрийн орлого 3,649.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь өмнөх оны газрын төлбөр төлөгдсөн;
- Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж 3,413.6 мянган төгрөгөөр давсан нь нэмэлтээр цагаан зээр агнасан төлбөр төлөгдсөн;

- Хөрөнгө борлуулсны орлого 5,660.6 мянган төгрөг төвлөрсөн нь орон нутгийн харьяат иргэдийн үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлогоос хуулийн дагуу төлөгдсөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сайхан-Овоо сумын ИТХ-ын 2023 оны 92 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,928,272.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,928,272.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Сайхан-Овоо сумын ИТХ-ын 2024 оны 105 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт өөрчлөлт оруулж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 36,360.0 мянган төгрөгөөр нэмж 1,964,632.5 мянган төгрөгөөр, сумын ИТХ-ын 2024 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан төсөвт өөрчлөлт оруулж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 15,906.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,980,538.7 мянган төгрөг болгон тайлант онд 2 удаа тодотгон баталсан байна. Тодотголын дийлэнх хувийг цалин хөлс, томилолтын зардал болон хөрөнгийн зардал эзэлж байна. Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын сарын 01-ний өдрөөс төрийн албаны үндсэн цалин нэмсэн, бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгодог болсон, мөн төрийн албан хаагчдын албан томилолтын зардлын тариф нэмэгдсэн, орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 1,980,538.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,375,442.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 500,834.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 104,262.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 360,351.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,405,267.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 106,800.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 108,120.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 345,937.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,323,685.1 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 64,860.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 120,911.9 мянган төгрөг, нийт 1,855,395.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 26,674.1 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 32,325.9 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлого 38,186.8 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 9,613.2 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нь Хоршоо хөгжүүлэх сангийн үндсэн зээл, хүүгийн орлого, туслах үйл ажиллагааны орлогод мал хамгаалах, байгаль хамгаалах сангийн орлого, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,548,967.0 мянган төгрөг буюу 78.2 хувьтай байгаа нь урсгал зардал 78,698.8 мянган төгрөг, хөрөнгийн зардал 298,611.0 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээл 54,262.0 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-г “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 29,985.5 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13,702.0 мянга, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 2,950.0 мянга, нийт 46,637.5 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна. Үүнээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 805.3 мянга, хангамж бараа материалын зардалд 10,331.7 мянга, эд хогшил урсгал засварын зардалд 2,893.0 мянга, томилолт зочны зардалд 1,191.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 5,877.2 мянга, бараа үйлчилгээний зардал 18,829.0 мянга, нийт 39,927.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үлдэгдэл 6,710.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Оюун-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг дарга 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн 01/57 дугаар албан бичигтэй санхүүгийн нэгтгэлийн программын засвартай холбоотой 2025 оны 03 сарын 10 өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын цэвэр хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгийн 4,073,890.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 40,738.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 28,517.2 мянган төгрөгөөр тогтоосон. Аудитын гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоож 40,794.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 28,556.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланг түүвэрлэн шалгахад 7,304.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 7,304.6 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хүргүүлсэн. Нэмэлт санхүүжилтээс 6,710.2 мянган төгрөгийг хэмнэж, буцаан төвлөрүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 14 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг дарга нь 2024 онд нийт давхардсан тоогоор 8,010,378.5 мянган төгрөгийн 58 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувь, хугацаа хоцролт 100 хувьтай зөрчилгүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын харьяа тусгай зориулалтын сан, төсөвт байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл хөтөлж, шалгагдагч байгууллагад танилцуулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 52,365.3 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө тасалсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. Харин санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 1,797.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 241,559.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагыг хүргүүлсэн байна. Акт албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	1,797.7	1	1,797.7			100.0
Албан шаардлага	4	245,453.1	4	245,453.1			100.0
<b>Нийт</b>	<b>5</b>	<b>247,250.8</b>	<b>4</b>	<b>247,250.8</b>			<b>100.0</b>

Өмнөх аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн тухай хариуг Төрийн аудитын газарт албан бичгээр болон санхүүгийн тайлангийн аудитын “<https://fas.audit.mn/>” системээр ирүүлсэн.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Татварын орлогын бүрдүүлэлт, түүний хэрэгжилтэд тавих хяналттай холбоотой асуудалд дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

## 5. Аудитын илрүүлэлт

### 5.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сайхан-Овоо сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчилд 34,025.3 мянган төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлжээ. Харин мал хамгаалах болон байгаль хамгаалах сангийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар

21,469.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 4,194.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 17,275.5 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг хүргүүлээ.

*Залруулсан алдаа:*

Аудитаар нийт 4,194.0 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Мал хамгаалах сангийн санхүүгийн өглөгийн тайланд байгууллагад өгөх өглөгийг илүү тайлагнасан;

*Залруулаагүй алдаа:*

Аудитаар нийт 51,300.8 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлсэн.

### **5.1. Албан шаардлага**

**5.1.1** Мал хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь 17,275.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д */дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/*, мөн хуулийн 20.2.6-д */эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/* Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д */өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх/*, Төсвийн тухай хуулийн 6.4.8-д */төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/*, 16.5.2-д */батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/* заасныг;

**5.1.2** Орон нутгийн татварын 3 нэр төрлийн орлогыг 34,025.3 мянган төгрөгөөр тасалсан.

Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.19-т */Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах/*, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т */Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ/*, 41.2.1-т */Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/* заасныг тус тус зөрчсөн байна.

### **5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

*Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:*

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудитад хамрагд	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	<b>НИЙТ</b>	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт дүнгээр 508,108.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 10,394.1 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 5,046.8 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 492,667.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 15 албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 98.0 хувийг залруулагдаагүй, 2.0 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 18,532.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 22,262.6 мянган төгрөгөөр буюу 2.2 дахин бага байна.

Иймд Сайхан-Овоо сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:**

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ	3	2,828.8	1	1,398.9	2	1,430.0	3	2,828.8				
ИТХ	1	2,636.4			1	2,636.4	1	2,636.4				
ОНХС	1	734.9			1	734.9	1	734.9				
МХС	1	4,194.0			1	4,194.0	1	4,194.0				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>10,394.1</b>	<b>1</b>	<b>1,398.9</b>	<b>3</b>	<b>8,995.3</b>	<b>6</b>	<b>10,394.1</b>			-	-

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	6	71,023.5	2	1,644.0	4	69,379.5						
ИТХ	2	1,683.4	1	351.40	1	1,332.0						
ХХС	2	12,968.3			2	12,968.3						
ОНХС	1	53,437.0			1	53,437.0						
МХС	1	17,275.5			1	17,275.5						
<b>Нийт дүн</b>	<b>12</b>	<b>156,387.7</b>	<b>3</b>	<b>1,995.4</b>	<b>9</b>	<b>154,392.3</b>					-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ЗДТГ	1	1,700.0			1	1,700.0						
ИТХ	2	5,604.6			1	5,604.6			1			
ХХС	1	3,051.4	1	3,051.4								
ОНХС	2	296,945.2			2	296,945.2						
ТТЗ	1	34,025.3			1	34,025.3						
	<b>7</b>	<b>341,326.4</b>	<b>1</b>	<b>3,051.4</b>	<b>5</b>	<b>338,275.1</b>			<b>1</b>			